

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

САНГИЙН ЯАМ, УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлд:

“XIX.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авахыг дор дурдсан Засгийн газрын гишүүдэд даалгав:

1. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

1.1. Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийг тусад нь санхүүжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг дотоод, гадаадын зээл, тусламж, шаардлагатай бусад эх үүсвэрийн хүрээнд шийдвэрлүүлэх асуудлыг судалж, саналаа яаралтай Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

1.2. Түүхий эдийг тээвэрлэх дамжуулах хоолойн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт:

2.1. Санхүүгийн эх үүсвэр шийдэгдэж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэний дараа бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР